



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/355

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын хүнс бараан захад бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд ажлын байр барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Нацаг -Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийтлэг үйлчилгээний албаны дарга

Нарийн бичгийн дарга: -Б.Пүрэвсүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон
нутгийн өмчийн газрын бараа, зөвлөх үйлчилгээ
худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: -Г.Гантөмөр Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн төслийн
ажилтан


-Н.Дулам Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт,
хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

-Ш.Авирмэд Бүтээлч хөгжлийн хөтөч ТББ-ын гишүүн (зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Б.Нацаг)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100570